

БАТЛАВ
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА М.БАЯРАА

.....2023.....оны.....11.....дүгээр сарын.....20.....

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

СУРГУУЛЬ ОРЧМЫН ЯВГАН ХҮНИЙ ГАРЦЫН
“ЛЕД ПРОЕКТОР” ГЭРЭЛТҮҮЛГИЙН АЖЛЫН ЗУРАГ
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Дугаар01.....

2023 оны 11 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2023 оны үйл ажиллагааны хөтөлбөр;- Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
2	Байршил	Нийслэлийн 9 дүүргийн сургууль орчмын явган хүний гарц
3	Одоогийн байдал	Сургуулийн орчмын бүсэд зарим гарцууд гэрлэн дохиогүй, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад стандартын тэмдэг тэмдэглэгээ бүхий гарцгүй, зарим байршилд зам тээврийн осол хэрэг давтамжтай үйлдэгддэг. <ul style="list-style-type: none">- ЛЕД проектор гэрэлтүүлэг хийгдээгүй- Шинээр төлөвлөх- Судалгаа хийх
4	Зураг төсөв боловсруулахад ашиглах материал	Норм нормативууд; <ul style="list-style-type: none">- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм- Цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм” БД 43.101.03- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНБД 30-10-04)- Хот, тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх /БД 30-102-11/- Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/;- Гэрэлтүүлэгт тавигдах ерөнхий шаардлага” хотын стандарт UCS1902B:2022- Гэрэлтүүлэх төхөөрөмжийг байрлуулах, суурилуулах технологийн удирдамж хотын стандарт UCS1902A:2022- Бусад холбогдох норм, дүрэм, заавар
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	Нийслэлийн Засаг даргын тамгын газар

7	Төсөл боловсруулах байгууллага	Тусгай зөвшөөрөлтэй гүйцэтгэгчийг шалгаруулна.
8	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	Хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн норм дүрмийн дагуу онцлох хэв маяг шийдлийг тусгаж өгөх; Гэрэлтүүлгийн шонг цаашид өргөтгөх боломжтойгоор зураг төсөлд тусгах
9	Инженерийн хангамж	<ul style="list-style-type: none"> - Техникийн нөхцөл, БНБД, БД, холбогдох стандартад тавигдсан шаардлагын дагуу тоног төхөөрөмж, кабель шугам, материалыг сонгох - Гэрэлтүүлгийн кабелин шугамын сувагчлалыг UCS1902B:2022 UCS1902A:2022 стандартын дагуу хийх - Цахилгаан хангамж: Төвлөрсөн цахилгаан хангамжийн шугам сүлжээнээс хангагдана.
10.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR -PRO программ болон түүнтэй ижил, цалинг дундаж зэргээр тооцдог, зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно.
11.	Төслийн санхүүжилт	- Нийслэлийн төсвийн хөрөнгө
12.	Төслийн иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> - Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгөх, - Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр УБЗАА, нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх, - Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөх - UB инженеринг цахим системд бүртгүүлэх
13.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Цахилгааны шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх, - Төлөвлөж буй цахилгаан хангамжийн шугам сүлжээнд одоо холбогдсон болон төлөвлөлтөөр холбогдох хэрэглэгчдийн ачааллыг тусгасан байх, - Ойр орчмын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгч компаниудын цахилгаан хангамжийн трасстай уялдуулан төлөвлөсөн байх, - Авто замын зорчих хэсэгт төлөвлөсөн инженерийн шугам сүлжээний хонгилын системтэй уялдуулах, - Зургийн төслийн ажлыг боловсруулахдаа дүүрэг, ашиглалт хариуцсан байгууллагатай газар дээр нь үзлэг хийж судалгаа гаргах, - Шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зай хэмжээ баримтлах,

		<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний хэмнэлттэй лед болон түүнтэй дүйцэхүйц шар тусгалтай гэрэлтүүлэгч сонгоно. - Инженерийн хангамжийн асуудлыг тооцоо, судалгааны үндсэн дээр хийх, - Гэрэлтүүлгийн зураг төсвийг гүйцэтгэхдээ доорх техникийн үзүүлэлтийг харгалзан үзнэ. - Зам хөндлөн гарах гэрэлтүүлгийн кабелин сувагчлалыг даацын хоолой, ус чийг тусгаарлалт сайтай материалаар хийж гүйцэтгэх
14	Техникийн тодорхойлолт	<ul style="list-style-type: none"> - Явган замын тэмдэглэгээг (-40, +40) халуун хүйтэнд тэсвэртэй, нарны хэт туяа, шуурга, доргилтонд тэсвэртэй, Gobo технологиор гэрэлтүүлэгтэйгээр шийдэх. <p>Хүчин чадал</p> <ul style="list-style-type: none"> -Өндөр нягтралтай ЛЕД чиптэй байх. - 5-7 жил тасралтгүй ажиллах насжилтай байх. - Хүчин чадал 320 ватт - Үндсэн тэжээл 220В - Өнгө 8000К - IP65 ба түүнээс дээш байх